

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.01.24-2017.02.22/

НЭГ: УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 5 удаа зохион байгуулж 11 асуудлыг хэлэлцэн баталсан байна.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Шивээ-Овоо хувьцаат компанитай хамтран сар шинийн баярыг тохиолдуулан сумын амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй үнээр буюу тонн тутам нь 2000 төгрөгийн үнэтэй нүүрс олгох ажлыг зохион байгуулж 80 гаруй тонн нүүрсийг 33 өрхөд хувиарлан олгосон байна.



Аймгийн ХХААГазартай хамтран 2017 оны 2-р сарын 01, 02-ны өдрүүдэд сумын малчин өрхүүдээр нийт 600 гаруй км явж малчдын өвөлжилтийн байдал, бог малын хээлтүүлэгч ялган суурьлуулах талаар, малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилгын гүйцэтгэлд хяналт тавих, хүний эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж ажилласан.





Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 02-р сарын 09-нд зохион байгуулж 7 асуудлыг хэлэлцэн батлав. Үүнд:

- Аймгийн “Алдарт уяач”-аар – Х.Төмөрбаатар
- Сумын “Сайн малчин”-аар – Б.Отгонбаатар
- Сумын “Алдарт уяач”-аар Л.Амаржаргал, Ч.Баттогтох

- Сумын мал сүргийг халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах мал, шаардагдах эм бэлдмэлийн 2018 оны захиалга

- Сумын нутаг дэвсгэрт худалдаа явуулах түр зөвшөөрөл олгох журмын төсөл,
- Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийг 2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл, - Сумын “Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 2017 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл зэрэг болно.

Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Сумын 2 дугаар багийн малчин Баянжаргалын Ганхуяг “Улсын аварга малчин”-аар тодорч Улсын их хурлын гишүүн Г.Мөнхцэцэг, аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, ХХААГ-ын дарга, сумын удирдлагууд 02-р сарын 19-ний өдөр шагналыг гардууллаа.



Сумын ИТХ-ын “Төлөөлөгчдийн нэг өдөр” өдөрлөгөөр “Мөсний баяр” арга хэмжээг албан байгууллага, аж ахуйн нэгж иргэдийн дунд 01-р сарын 11-нд 3 төрлөөр зохион байгуулж 8 багийн 80 тамирчид оролцсоноос төрөл тус бүрт 1, 2-р байрыг шалгаруулж багийн нийт оноогоор **"ЭНХ-ОЮУ ДЭВЖИХ" ХХК** шалгарч Тэргүүн байр эзэлсэн байна.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2017 оны 02-р сарын 22-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.


№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	6 969 000	5 708 930
2.	ЗДТГ	51 625 500	43 149 332

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	48 950 000	38 904 491
2.	Соёлын төв	9 766 000	9 267 800
3.	3-р сургууль	190 706 000	179 120 898
4.	3-р цэцэрлэг	76 176 800	64 572 060

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Говьсүмбэр аймгийн шүүхтэй хамтран сумын төсвийн байгууллагын ажилчид болон иргэдэд “Шүүхийн багц хууль”-ийн талаар сургалт зохион байгуулж хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй хэлэлцүүлгийг 02 сарын 03-нд зохион байгуулж 117 иргэн оролцсон байна.




Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл 02 сарын 23-ны өдөр хуралдаж 2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн төвтэй хамтран 3-р сургуулийн дунд, ахлах бүлгийн сурагчдын дунд "Дэлгэцийн донтолгоос урьдчилан сэргийлэх", "Архи тамхины нөлөөлөл" сэдэвт сургалтуудыг зохион байгуулж сургалтын сэдэвтэй холбоотой танин мэдэхүйн А.Х.А тэмцээн зохион байгуулсан. Сургалтанд нийт 77 сурагчид хамрагдсан байна.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

12 ангийн суралцагчдаас ЭШ-нд бэлтгэх сорилго шалгалтыг авлаа.



II улирлын дүнгийн нэгтгэлийн гүйцэтгэлийн хувийг графикжуулан харуулав.





Монголын боловсролын “Манлай багш” шалгаруулах арга хэмжээнд 3-р сургуулийн багш Ё.Бадамсүрэн, Г.Зоригт, О.Сарантуяа нар шалгарч “Манлай багш” одонгоор шагнагдлаа.

хамрагдлаа.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан үе тэнгийн сургагч багшийн сургагч багшийн сургалтанд



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 30 өвчтөн хэвтэж үүнээс 8 хүүхэд эмчлүүлсэн байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

1. Урьдчилан сэргийлэх үзлэгийг – 125
2. Дуудлага - 56
3. Амбулаторийн үзлэгт нийт -411 иргэн хамрагдсан байна. Томуу томуу төст өвчний дэгдэлт буурч байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материал. Эм тарианы хангалтгүй эмчилгээ үйлчилгээ бүрэн хийгдэхгүй тасалдалтай байна.

Эмнэлгийн эмч, ажилчид Хүүхэд хамгаалалын хамтарсан багийн сургалт, Швейцарийн хөгжлийн агентлаг Дэлхийн банкны хөрөнгө оруулалттай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх нь сэдэвт төслийн “Халдварт бус өвчний үед зөвлөгөө өгөх ур чадвараа хөгжүүлэх нь” сэдэвт сургалт, Монголын Нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгийн сургалтанд тус тус хамрагдсан.

ХДХВ, БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2017 оны 01 сарын 27-ны өдөр “Шивээ-Овоо” ХК-ийн ажилтнуудад зохион байгуулж, тэмбүү өвчнийг илрүүлэх шинжилгээ авч ажилласан.



Нярай хүүхэдтэй ээжүүдэд эхийн сүүгээр хооллолтын ач тус, томуу томуу төст өвчний талаарх мэдээлэл зөвлөгөөг гэрээр өгч ажиллаж байна.

Хүүхдийн түлэгдэлт - Эцэг эхийн хариуцлагаас аяны хүрээнд 0-5 насны хүүхдүүдтэй эцэг эхчүүдэд “Түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх” сургалтыг 3-р цэцэрлэгтэй хамтран зохион байгуулж нийт 90 эцэг эх хамрагдсан. Мөн сумын 1-р багийн 442, 2-р багийн 194 өрхөд урьдчилан сэргийлэх мэдээлэл мессежийг иргэний танхимын утсаар иргэдэд мэдээллэн ажилласан.



3-Р ЦЭЦЭРЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын үнэлгээний Локал программ дээр ажиллах арга зүйн сургалтанд бүлгийн багш нар 2017 оны 02 сарын 02, 03-ны өдрүүдэд хамрагдлаа.

Аймгийн номын сангаас зохион байгуулсан “Цагаан сар ба ёс заншил” арга хэмжээнд цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүд амжилттай оролцлоо.



СОЁЛЫН ТӨВ

Соёлын төвийн Мини кино театрын тоног төхөөрөмжийг хэвийн үйл ажиллагаанд оруулж, 7 хоног тутам кино гаргаж байхаар төлөвлөн 2-р сард Монголын уран сайхны “ADMIN-Z”, “Сайн аав” зэрэг кинонуудыг гарган ажилласан.

Бага насны хүүхдийн ярих чадварыг сайжруулах, хэл зүгшрүүлэх зорилгоор “УРАН ЖИРГЭЭ- 2017” шүлгийн уралдааныг 3-р цэцэрлэгтэй хамтран 4 төрлөөр зохион байгууллаа. Үүнд: үлгэр, ёгт элэглэл, ерөөл магтаал, шүлэг унших, анги нийтийн шүлэг гэсэн төрлүүдээр зохион байгуулж аваргаа шалгаруулан шагнаж урамшуулсан.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2017.02.13-ний өдөр зохион байгуулан 7 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн. Үүнд:

1. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэнд сар бүр олгодог асаргааны мөнгөн тэтгэмжийн сунгалт - 2 иргэн
2. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэнд сар бүр олгодог асаргааны мөнгөн тэтгэмжид шинээр хамрагдах - 1 иргэн
3. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртлэх насны хүүхдэд сар бүр олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн сунгалт - 1
4. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртлэх насны хүүхдэд сар бүр олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн сунгалт - 1 иргэн
5. Байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнд улиралд нэг удаа олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн сунгалт – 1 иргэн
6. Байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнд улиралд нэг удаа олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид шинээр – 1 иргэн тус тус хамрагдсан.

2017 оны 02-р сарын 7-оос эхлэн Ахмад настаны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу “Насны хишиг” олгох ажлыг зохион байгуулж 82 ахмад настанд 6020000 төгрөгийг олгоод байна. Үүнд:

- 65-69 настай 32 ахмад настанд 1600000 төгрөг
- 70-79 настай 44 ахмад настанд 3520000 төгрөг
- 80-89 настай 6 ахмад настанд 900000

Ахмад настаны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу Сар шинийн баярыг тохиолдуулан сумын харъяалалгүй 53 ахмад настанд 530000 төгрөгийг олгож хүндэтгэл үзүүлсэн.

УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 90 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 12 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2017 оны 2 сарын 21-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 6 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн 46 гэрчилгээг олгосон.

Иргэдээс энэ сард 65 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдуулан хаягийн зөрчлийг арилгах нэг сарын аян зарлаж аяны хүрээнд хаягийн давхардалтыг арилгах, орон нутагт шилжүүлэггүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг гаргаж орон нутгийн шилжүүлэгийг хийлгэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

Мөн 2000-2005 онд нас барсан боловч регстрийн дугаар болон овог, нэрийн зөрүүтэйгээс мэдээллийн санд ороогүй байсан 5 иргэний мэдээллийг архиваас шүүж нөхөн бүртгэж, мэдээллийн санд оруулаад байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2017 ОНЫ 02 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	12				12	7	5
Төрсөн эх	2	12				12	-	12
Бүртгүүлсэн гэр бүл	3	1				1	1	1
Нас баралт	4	2				2	1	1
Цуцалсан гэр бүл	5	-				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	23				23	14	9
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	31				31	16	15

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

2017.02.21.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2017 оны 2-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Эцэг тогтоолт	2500	3	7500				
2	᠐°ᠳᠠᠨᠢᠳᠡᠭ ᠠᠶᠢᠳᠡᠭᠠᠨ ᠠᠶᠢᠳᠡᠭ ᠠᠶᠢᠳᠡᠭ	5000	3	15000				
3	Иргэний үнэмлэхний үнэ	15000	12	180000	3300	12	39600	
4	ᠢᠳᠡᠨᠡᠭᠡ ᠡᠯᠡᠳᠡᠭᠡ ᠠᠶᠢᠳᠡᠭᠡ	5000	6	30000	1000	6	6000	

5	өөр аймаг луу шилжин явсан	2500	6	1500	1000	6	6000	
6	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	7	10500	1000	7	7000	
ДҮН		258000			58600			
НИЙТ ДҮН		316600						

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Сар шинийн баярыг угтаж иргэдийн худалдан авалтыг нэг дороос хямд, чанартай бараа бүтээгдэхүүн худалдан авах боломжоор хангах, орон нутгийн бизнес эрхлэгчид, малчдын бүтээгдэхүүнийг сурталчилах зорилгоор “Элбэг дэлбэг цагаан сар” үзэсгэлэн худалдааг 2017 оны 02-р сарын 13-нд зохион байгуулж 10 иргэн 13 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 1.085.000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.



Эцэг малыг сүргээс тусгаарлах, ялган суурьлуулах ажлыг 02-р сарын 16-наас эхлэн зохион байгуулж 2-р багийн малчин Б.Батбаатартай гэрээ байгуулан хүлээлгэн өгөөд байна.

2018 онд мал сүргийг халдварт паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг ИТХТ-ийн хурлаар батлуулан аймгийн ХХААГазарт хүргүүлсэн.

БАЙГАЛЬ ОРЧИН

Сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 28 ААНБ-ын 179 иргэн хамрагдаж 42 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төв хогийн цэгт ачиж зайлуулсан байна.



МЭДЭЭ ГАРГАСАН:

МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА